



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2007 оны 01 дугаар
сарын 19 -ны өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 3 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг.Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Автобаазын дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр.Автобаазын дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Ц.Болдсайхан /-т үүрэг болгосугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх Захиргааны 1992 оны 78 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 2001 оны 48 тоот захирамжийн хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АВТОБААЗЫН / УУГАЗАР / ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Автобааз нь /цаашид "Автобааз" гэх/ Нийслэлийн болон дүүргийн Засаг даргын Тамгын газар, харъяа байгууллага, хэлтсүүдийн ажлын үйлчилгээнд автомашинаар үйлчлэх, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, чиглэлд тусгагдсан бодлого, удирдамжийг хэрэгжүүлэх үүрэг бүхий өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллах Нийслэлийн өмчит улсын үйлдвэрийн газар мөн.

1.2.Автобааз нь үйл ажиллагаандаа Иргэний хууль, Хөдөлмөрийн хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Засгийн газар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын тогтоол, шийдвэр, энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана.

1.3.Автобаазын даргыг Нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

1.4. Ажилтан, албан хаагчдыг автобаазын дарга ажилд томилж, ажлаас чөлөөлнө.

1.5.Автобаазын дарга нь автобаазын цаашид хэрэгжүүлэх зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хотын Засаг даргын өмнө хариуцаж, тайлагнах бөгөөд эрх хэмжээний хүрээнд Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн тушаал шийдвэр гаргана.

1.6.Автобааз нь банкны байгууллагад харилцах данстай, гадаад, дотоодын аж ахуйн нэгж байгууллага, иргэдтэй гэрээ хэлцэл байгуулан ажиллах хуулийн этгээд бөгөөд орлогоороо зардлаа нөхөх зарчмаар ажиллана.

1.7.Авто бааз нь нийслэлийн Засаг дарга, орлогч, Тамгын газрын даргын болон Нийтлэг үйлчилгээний газрын удирдлагад үйл ажиллагаагаа явуулж, ажлаа тайлагнана.

1.8.Хөдөлмөрийн тухай хуульд нийцсэн автобаазын дотоод журам боловсруулан мөрдөн ажиллана.

1.9.Автобааз нь тогтоогдсон журмаар хийсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

1.10. Автобаазын дарга нь эрх хэмжээний хүрээнд тушаал гаргана.

1.11.Автобаазын дарга нь дэргэдээ байгууллагын зорилт чиг үүргийг хэрэгжүүлэхэд зөвлөх эрх бүхий зөвлөлтэй байж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг автобаазын дарга батална.

Хоёр.Автобаазын үүрэг

2.1.Автобаазын дарга нь тухайн жилийн үйл ажиллагааны зорилтот түвшинг тодорхойлон автобаазын ашиг орлогыг нэмэгдүүлэх, чанарыг дээшлүүлэх талаар асуудал боловсруулж шийдвэрлүүлэх, түүнийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үндсэн үүрэг хүлээнэ.

2.2.Автобаазын санхүүгийн тогтвортой байдлыг хангаж, техник технологи, парк ашиглалтыг сайжруулах, нэмэгдүүлэх хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, өртөг зардлыг багасгана.

2.3.Ажиллагчдын техникийн болон эдийн засаг, эрх зүйн мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх, давтан бэлтгэх, гэрээ, захиалгын үндсэн дээр өөрийн зардлаар боловсон хүчин бэлтгэх арга хэмжээ авах, автомашинаар үйлчлэх ажлыг чанарын өндөр түвшинд гомдол чирэгдэлгүйгээр явуулж байна.

2.4.Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн хуулинд заасан журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж, нягтлан бодох бүртгэлийн тайлан балансыг аргачлалын дагуу зохих мэдээ тайлан гаргах ажлыг зохион байгуулна.

2.5.Автобааз нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих хяналтыг зохион байгуулах, эд хөрөнгийн дотоодын тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулинд заасан журам, хугацааны дагуу явуулна.

2.6.Шатахуун тослох материал, автомашины сэлбэг, дулаан, цахилгаан, усны үнэ нэмэгдэхэд үйлчилгээний үнэ тарифыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, бусад холбогдох газруудтай хамтран өөрчлөх санал боловсруулан Нийслэлийн Засаг даргад танилцуулан, шийдвэрлүүлэн мөрдөн ажиллана.

Гурав.Автобаазын эрх

3.1.Автобаазын хөрөнгийг Монгол улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон энэхүү дүрэмд нийцүүлэн эзэмшин ажиллаж, захиран зарцуулна.

3.2.Ажиллагсдад ур чадварын нэмэгдэл, буцалтгүй тэтгэмж олгох нөхцөл журмыг тогтоон мөрдүүлэх, тогтоосон журмын дагуу гадаад худалдааны үйл ажиллагаа явуулах, Нийслэлийн Засаг даргын зөвшөөрөлтэйгээр гэрээ контракт байгуулана.

3.3. Норм хугацаа дууссан автомашин, тоног төхөөрөмжийг бусдад худалдах, шилжүүлэх, данснаас хасах, түрээслэхийг Нийслэлийн Өмчийн газар, Нийслэлийн Засаг даргын зөвшөөрлөөр шийдвэрлэнэ.

3.4.Автобаазад ажиллагчдын тоо, мэргэжлийн бүрэлдэхүүн, удирдлагын аппаратын цалингийн санг тогтооно.